



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/388

Сүхбаатар


Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлийн заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүхбаатар суманд 50 хүүхдийн ортой хувийн хэвшлийн “Эрдмийн чуулган” цэцэрлэгийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

2.“Эрдмийн чуулган” цэцэрлэгийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, сургалтын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга /Ж.Батсайхан/, мэргэжил арга зүйн удирдлагаар бүрэн хангаж ажиллахыг аймгийн Боловсролын газрын дарга /Д.Загдгочоо/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БҮРЭНБАТ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/46


Сүхбаатар

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол суманд шинээр ашиглалтанд орсон 50 хүүхдийн ортой хувийн хэвшлийн “Бүжинхэн” цэцэрлэгийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

2.“Бүжинхэн” цэцэрлэгийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, сургалтын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга /Ж.Батсайхан/, мэргэжил арга зүйн удирдлагаар бүрэн хангаж ажиллахыг аймгийн Боловсролын газрын дарга /Д.Загдгочоо/-д тус тус үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ